

Төлөвлөгөөт хяналт шалгалт
хийсэн тухай

Хяналт шалгалтын зорилго

Санхүүгийн хяналт аудитын албаны 2017 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, Санхүүгийн хяналт аудитын албаны даргын баталсан 2017 оны 04 сарын 10-ны 1/06 дугаар удирдамжийн дагуу санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох дүрэм, журам, тушаалуудын хэрэгжилтийг хангуулах, үндсэн үйл ажиллагааны байдал, зохион байгуулалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагааны байдлыг шалгаж, үнэлэлт дүгнэлт өгөх, ололт амжилтыг бататгаж, зөрчил дутагдлыг арилгахад оршино.

Хяналт шалгалтын бүрэлдэхүүн, албан тушаал, хугацаа

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч О.Гантуяа
2017 оны 04 дугаар сарын 17-аас ажлын 6 хоног

Шалгалтанд хамрагдсан байгууллага, объектын нэр

Рашаант сумын Эрүүл мэндийн төвийн 2015, 2016 онуудын санхүү, аж ахуйн үйл ажиллагаа хамрагдав.

Шалгалтанд хамрагдсан асуудал

Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн гаргасан заавар, журам, дүрмийн хэрэгжилтийн байдал

Үйл ажиллагааны орлого, зарлагын төлөвлөлт, түүний гүйцэтгэлийн байдал
Харилцах дансны болон кассын орлого, зарлагын гүйлгээг үндсэн баримтууд, бараа материалын тайлан, хөрөнгийн бүртгэл, нягтлан бодох бүртгэлийн журналууд, дансны бичилтүүдтэй тулган шалгах

Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайлан тэнцэл гаргалт, хөрөнгийн тооллого, тооцоо бодолтын байдал

Байгууллага хоорондын тооцоо өглөг авлага, түүний баталгаажуулалт, бүртгэл тайланд тусгасан байдал

Ажиллагсдын цалин хөлс, шагнал урамшууллыгхууль тогтоомжийн дагуу тогтоож, бодож олгосон байдал

Гадаад, дотоод албан томилолтын зардлын тооцоо төлсөн байдал
Автомашин ашиглалт, шатахуун, сэлбэгийн тооцоо бодолтын байдал
Зээл тусламж, эргэж төлөгдөх нөхцлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалт үр дүн

Тэмдэглэлт өдөр, ой, баяр наадамд зарцуулсан хөрөнгийн байдал
Нягтлан бодогчийн хууль тогтоомжинд заасан үүргийн биелэлт
Өмнөх шалгалтаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, актын барагдуулалт

Дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байдал

Шалгалтанд хамрагдсан объектын талаарх

ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Рашаант сумын Эрүүл мэндийн төв нь дарга, их эмч 2, статистикч бага эмч 1, эх баригч бага эмч 1, ББЧ-ийн бага эмч 1, ахлах сувилагч, сургалтын арга зүйч 1, лаборант, вакцинатор 1, нярав сувилагч 1, ээлжийн сувилагч 4, асрагч 4, тогооч, жолооч тус бүр 1 нийт 19 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

2015 оны 01 сарын 01-нээс 2015 оны 07 сарын 01-ний өдрийг хүртэл 1-р гарын үсгийг дарга Ц.Гиймаа, 2015 оны 07 сарын 01-нээс 2016 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэл 1-р гарын үсгийг дарга Д.Жаргалсайхан, 2015 оны 01 сарын 01-нээс 2015 оны 09 сарын 01-ний өдрийг хүртэл 2-р гарын үсгийг нягтлан бодогч С.Шинэбилэг, 2015 оны 09 сарын 01-нээс 2016 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэл 2-р гарын үсгийг нягтлан бодогч Ц.Энхбаяр нар тус тус зурсан ба төрийн санд бүртгэлийн 041620001 тоот данс, нэмэлт санхүүжилтийн 041620401 тоот данстайгаар орлого, зарлагын гүйлгээг хийж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулж иржээ.

Нягтлан бодох бүртгэлийг санхүүгийн тооцоолох “CTS” программаар бүртгэж хөтөлсөн байна.

Өмнөх шалгалтын талаар

Эрүүл мэндийн төвийн 2015, 2016 оны санхүүгийн тайлангууд түүвэрт хамрагдсан,

эрүүл мэндийн төвийн 2015, 2016 оны санхүү аж ахуйн үйл ажиллагаанд бусад байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Шалгалтын явцад хийгдсэн ажил,

шийдвэрлэсэн асуудал

Тус Эрүүл мэндийн төвийн 2015, 2016 оны касс, харилцахын баримт, няравын материалын тайлан, нягтлан бодох бүртгэлийн журнал, эрхлэгчийн тушаал,

цалингийн карт, цалин олгох хүснэгт, нийгмийн даатгалын болон татварын, санхүүгийн тайлан, 2015, 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын газрын дүгнэлт зэрэг баримт материалуудад тулгуурлан эрхлэгч эмч Д.Жаргалсайхан, нягтлан бодогч С.Шинэбилэг, Ц.Энхбаяр нярав С.Сийлэгмаа нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийлээ.

Санхүүжилт, орлогын талаар: /мянган төгрөг/

2015 онд төсвөөс 293112.5 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 291624.1 мянган төгрөгийг авч, үндсэн үйл ажиллагааны орлогыг 142.8 мянган төгрөгөөр төлөвлөж, 142.8 мянган төгрөгийг оруулж, нийгмийн даатгалын сангаас ХЧТА-ны тэтгэмж 2 хүн, ЖА-ний тэтгэмж 1 нийт 2358.4 мянган төгрөг нийт 294125.3 мянган төгрөгийн эх үүсвэртэй ажилласан байна.

2016 онд төсвөөс 300452.4 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 300452.4 мянган төгрөгийг авч, нэмэлт санхүүжилтийн дансаар 1211.7 мянган төгрөг нийт 301664.1 мянган төгрөгийн эх үүсвэртэй ажилласан байна.

Төсөвт зардлын талаар /мян.төг/

2015 онд төсөвт зардлыг 293255.3 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 291766.9 мянган төгрөгийг зарцуулсан байна. Ажилчдын цалинд 174817.8 мянган төгрөг, гэрээт ажилчдын цалинд 30337.1 мянган төгрөг, ндш-д 22689.1 мянган төгрөг, тогтмол зардалд 24376.8 мянган төгрөг, хангамжийн бараа материалд 10290.1 мянган төгрөг, нормативт зардал буюу эм, хоол хүнс 16847.7 мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэл 2386.0 мянган төгрөг, урсгал засвар 992.6 мянган төгрөг, томилолт 749.8 мянган төгрөг, төлбөр хураамж бусад татварууд 538.5 мянган төгрөг, жижиг эд хогшил 349.7 мянган төгрөг, биеийн тамир уралдаан 100.0 мянган төгрөг, хог хаягдал 516.6 мянган төгрөг, хөтөлбөр төсөл буюу хичээл үйлдвэрлэлийн дадлага 4225.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 200.0 мянган төгрөг тус тус зарцуулж, 2 хүнд ХЧТА-ны тэтгэмж, 1 хүний ЖА-ны тэтгэмж нийт 2358.4 мянган төгрөгийг өгч, үлдэгдэл 2349.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Эрүүл мэндийн төвийн даргын 2015 оны 04 сарын 10-ны өдрийн 09 дугаартай тушаалаар 22 ажилтанд 21-30%-иар 2896.5 мянган төгрөгийн, 2015 оны 06 сарын 16-ны өдрийн 21 дугаартай тушаалаар 22 ажилтанд 12-39%-иар 3531.9 мянган төгрөгийн, 2015 оны 09 сарын 25-ны өдрийн 32 дугаартай тушаалаар 18 ажилтанд 11-36%-иар 2106.8 мянган төгрөгийн, 2015 оны 12 сарын 16-ны өдрийн Б/48 дугаартай тушаалаар 22 ажилтанд 20-42%-иар 4037.3 мянган төгрөгийн, мөн 12 сарын 17-ны өдрийн 47,48 дугаартай тушаалаар 5 ажилтанд тус бүрт 1 сарын цалин 681.3 мянган төгрөгийн нийт 11134.6 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалин олгосон байна.

Эрүүл мэндийн төвийн эрхлэгч Ц.Гиймаад 2015 оны 1 улиралд ажлын шалгуур үзүүлэлтийг дүгнэлгүйгээр 235.1 мянган төгрөгийн, 2 улирлын ажлыг

дүгнэж үндсэн цалингийн 36%-иар урамшуулж 217.0 мянган төгрөгийн, Эрүүл мэндийн төвийн эрхлэгч Д.Жаргалсайханд 3 улирлын ажлыг дүгнэж үндсэн цалингийн 20.4%-иар урамшуулж 117.4 мянган төгрөг, 4 улирлын ажлыг дүгнэж үндсэн цалингийн 36%-иар урамшуулж 206.7 мянган төгрөг, Рашаант сумын Засаг даргын 2015 оны 11 сарын 20-ны өдрийн Б/136 дугаар захирамжаар хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан тул 1 сарын үндсэн цалингаар 574.3 мянган төгрөгийн, 12 сарын 17-ны өдрийн 144 дүгээр захирамжаар төсвийн ерөнхийлэн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээг А үнэлгээтэй дүгнүүлсэн тул 0.5 сарын цалингаар 287.1 мянган төгрөг нийт 1637.6 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалин олгосон байна.

2016 онд төсөвт зардлыг 300452.4 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 301664.1 мянган төгрөгийг зарцуулсан байна. Ажилчдын цалинд 180701.6 мянган төгрөг, нэмэгдэл цалинд 13113.5 мянган төгрөг, ндш-д 21206.6 мянган төгрөг, тогтмол зардалд 24787.0 мянган төгрөг, хангамжийн бараа материалд 14068.9 мянган төгрөг, нормативт зардал буюу эм 16500.0 мянган төгрөг, хоол хүнс 4700.0 мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэл 2570.0 мянган төгрөг, эд хогшил болон урсгал зардалд 4172.0 мянган төгрөг, томилолт 811.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил 12693.2 мянган төгрөг, төлбөр хураамж бусад татварууд 512.8 мянган төгрөг, хөтөлбөр төсөл буюу хичээл үйлдвэрлэлийн дадлага 5497.9 мянган төгрөгийг тус тус зарцуулж, үлдэгдэл 841.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Эрүүл мэндийн төвийн даргын 2016 оны 04 сарын 22-ны өдрийн 23 дугаартай тушаалаар 18 ажилтанд 12-39%-иар 3138.5 мянган төгрөгийн, 2016 оны 07 сарын 04-ний өдрийн 44 дугаартай тушаалаар 17 ажилтанд 12-42%-иар 3211.0 мянган төгрөгийн, 2016 оны 10 сарын 26-ны өдрийн 56 дугаартай тушаалаар 19 ажилтанд 26-45%-иар 3056.3 мянган төгрөгийн, 2016 оны 12 сарын 16-ны өдрийн 67 дугаартай тушаалаар 17 ажилтанд 33-45%-иар 3414.6 мянган төгрөгийн нийт 12820.4 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалин олгосон байна.

Эрүүл мэндийн төвийн эрхлэгч эмч Д.Жаргалсайханд Рашаант сумын Засаг даргын 2016 оны 04 сарын 08-ны өдрийн А/40 дүгээр захирамжаар 1 сарын цалингаар 602.9 мянган төгрөг, 2016 оны 1 улирлын ажлыг дүгнэж үндсэн цалингийн 30%-иар урамшуулж 180.8 мянган төгрөгийн, 2 улирлын ажлыг дүгнэж үндсэн цалингийн 42%-иар урамшуулж 253.2 мянган төгрөгийн, 2016 оны 10 сарын 28-ны өдрийн А/120 дугаар захирамжаар 3 улирлын ажлыг дүгнэж үндсэн цалингийн 28%-иар урамшуулж 168.8 мянган төгрөг, 2016 оны 12 сарын 20-ны өдрийн А/148 дугаар захирамжаар 4 улирлын ажлыг дүгнэж үндсэн цалингийн 39%-иар урамшуулж 274.3 мянган төгрөг, 2016 оны 12 сарын 20-ны өдрийн А/149 дүгээр захирамжаар хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан тул 1 сарын үндсэн цалингаар 703.5 мянган төгрөгийн нийт 2183.5 мянган төгрөгийн үр дүнгийн болон урамшуулалт цалин олгосон байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын тайлангаар:

2015 оны үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 774118.0 мянган төгрөг дээр 180.0 мянган төгрөгийн принтерийг хандиваар авч үндсэн хөрөнгөнд орлогодож, Эрүүл мэндийн төвийн даргын 2015 оны 12 сарын 30-ны 50 тоот тушаалаар 650.0 мянган төгрөгийн компьютер, 211.8 мянган төгрөгийн принтер, 48.3 мянган төгрөгийн нярайн кило, 185.4 мянган төгрөгийн хөргөгч, 155.7 мянган төгрөгийн төмөр саарал шкаф, 45.2 мянган төгрөгийн гэрийн зуух, 50.7 мянган төгрөгийн оёдлын машин, 70.3 мянган төгрөгийн нийт 1417.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, эд хогшлийг акталж, 772880.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

2016 оны үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 772880.5 мянган төгрөг дээр төсвийн хөрөнгөөр угаалгын машин 260.0 мянган төгрөг, зургийн аппарат 370.0 мянган төгрөг, принтер 180.0 мянган төгрөг нийт 810.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг 2016 оны 11 сарын 23-ны ИТХ- тэргүүлэгчдийн 43 тоот тогтоолоор бэлтгэж орлогодсон, ЭМГ-аас зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, утлагын аппарат, Dell компьютер зэрэг 4242.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгөнд орлогодож, 777932.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

Бараа материалын 2015 оны эхний үлдэгдэл 21851.7 мянган төгрөг дээр эм боох материал 11806.1 мянган төгрөг, бичиг хэрэг 395.0 мянган төгрөг, аж ахуйн материал 1511.4 мянган төгрөг, түлш, шатах тослох материал 25559.4 мянган төгрөг, засварын материал 226.5 мянган төгрөг, хүнсний материал 4952.2 мянган төгрөг нийт 44450.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 87.0 мянган төгрөгийн эм хандиваар авч, 40986.0 мянган төгрөгийн материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, 2221.9 мянган төгрөгийн аж ахуйн материал акталж оны эцэст 23181.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

Бараа материалын 2016 оны эхний үлдэгдэл 23181.5 мянган төгрөг дээр эм боох материал 16500.0 мянган төгрөг, бичиг хэрэг 878.6 мянган төгрөг, аж ахуйн материал 6935.9 мянган төгрөг, түлш, шатах тослох материал 30985.0 мянган төгрөг, засварын материал 1372.0 мянган төгрөг, хүнсний материал 4730.0 мянган төгрөг нийт 61401.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 92.4 мянган төгрөгийн эм, 1837.0 мянган төгрөгийн аж ахуйн материал хандиваар авч, 54513.0 мянган төгрөгийн материалыг үйл ажиллагаандаа зарцуулж оны эцэст 31999.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна

Өглөг, авлагын талаар: Эрүүл мэндийн төв нь 2015, 2016 онд өглөг, авлагагүй тайлан гарсан байна.

Нэмэлт санхүүжилт: Нэмэлт санхүүжилтийн дансанд эрүүл мэндийн газраас бензин шатахууны зардалд 411.8 мянган төгрөг, Онцгой байдлын газраас түргэн тусламжийн автомашины дугуйны зардалд 800.0 мянган төгрөг нийт 1211.8 мянган төгрөгийг зарцуулсан ч тайланг дээд газарт явуулсан байна.

Шилэн дансны талаар: Эрүүл мэндийн төв нь шилэн дансны хуулийн дагуу 2016 онд мэдээллийг тавьсан ч батлагдсан төсөв гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн

шалтгааны 12, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, концессын зүйлийн жагсаалтын 13, байгууллагын орон тоонд орсон өөрчлөлтийн 12, аудитын тайлан, худалдан авах ажиллагаанд хийсэн тайлан тус бүр нэг нэг нийт 38 мэдээлэлийг хоцроож байршуулсан.

Шалгуулагчийн ололттой болон дэвшилттэй тал

1. Санхүүгийн тайлан балансыг цаг хугацаанд гаргаж тушаасан
2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үзүүлэлтээр аймагт 2-р байр эзэлсэн

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал

1. Хүнс болон бараа материалын агуулахын бүртгэлийг хөтөлдөггүй, шатахууныг авсан хэмжээгээр зардалд тусгадаг, жолоочтой шатахууны хэтрэлт, хэмнэлтийг тооцоог бодож акт үйлддэггүй.
2. Иргэдээс мах болон сүү тараг худалдан авахдаа шинжилгээний бичиг авч санхүүгийн баримтанд архивлаагүй байна.
3. Цалин олгох болон цалингийн тооцооны хүснэгт, цалингийн картанд ажиллагсдаар гарын үсэг зуруулаагүй байна.
4. Эм болон хүнсний материалаас бусад материалын тайланг зардлын нэр төрлөөр гаргаагүй нийлүүлж тайлан гаргадаг.
5. 2015 оны 3, 4, 5, 6 сарын төлбөрийн хүсэлтэд ЭМТ-ийн данс бичигдээгүй, 2016 оны 07 сарын 27-ны өдрийн 278 тоот төлбөрийн хүсэлтээр “Холбоо баянбүрд” ХХК-д 26.9 мянган төгрөгийн хүнсний материалын үнийг шилжүүлэхдээ даргын гарын үсэг, тамга тэмдэггүйгээр тус бүр гүйлгээ хийгдсэн.
6. 2015 оны 03 сарын 27-ны өдрийн 032723 тоот төлбөрийн хүсэлтээр Д.Энхцэцэгийн Төрийн банкны 12100002542 тоот дансанд цалингийн урьдчилгаанд 140.0 мянган төгрөг өгсөн. 2015 оны 4 дүгээр сарын цалингаас 70.0 мянган төгрөгийн урьдчилгааг суутгасан. Үлдэгдэл 70.0 мянган төгрөгийг он дуустал суутгаагүй, авлагаар тусгаагүй байна.
7. ЭМТ-ийн даргын 2015 оны 03 сарын 05-ны өдрийн 06 дугаар тоот тушаалаар статистикч бага эмч Д.Сарантуяад архив бичиг хэргийн ажилтны мэргэжлийн ахлах зэргийн нэмэгдлийг үндсэн цалингийн 10 хувиар буюу 4,5,6 сард нийт 176379 төгрөгийг батлагдаагүй орон тоонд зэргийн нэмэгдэл цалин олгосон.
8. ЭМТ-ийн даргын 2015 оны 05 сарын 24-ны өдрийн 18 дугаар тоот тушаалаар хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр эмнэлгийн эмч, ажиллагсдын 25 хүүхдэд төсвөөс 250.0 мянган төгрөг гаргаж тус бүрт 10.0 мянган төгрөгийн үнэтэй бэлэг авч өгсөн нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалтыг зөрчин зориулалт бусаар олгосон.

9. ЭМТ-ийн дарга Ц.Гиймааг өөр нутагт шилжин ажиллах болсон тул 2015 оны 06 сарын 05-ны өдрийн 90 дүгээр, 2015 оны 06 сарын 30-ны өдрийн 99 дүгээр захирамжаар тус тус ажлаас чөлөөлсөн 2 захирамж гарсан байна. 90 дүгээр захирамж нь Рашаант сумын Засаг даргын 2015 оны захирамжийн баримтын архивын улсын үзлэгийг угтаж бэлтгэл хангах ажлын комисс томилох захирамжтай дугаар нь давхцсан, 99 дүгээр захирамж нь санхүүгийн баримт болон Рашаант сумын Засаг даргын 2015 оны захирамжийн баримтанд байхгүй байсныг тухайн иргэнээс өөрөөс нь мейл хаягаар авлаа.
10. Ажлын шалгуур үзүүлэлтийг дүгнэсэн баримтгүйгээр, улирал бүр тушаалаар статистикч бага эмч Д.Сарантуяад 1250.6 мянган төгрөг, жолооч С.Энхбатад 424.6 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг тушаалаар олгосон.
11. Жолооч С.Энхбатад сахилгын хариуцлага тооцож нэг сарын үндсэн цалинг 20%-иар бууруулахаар байгууллагын даргын тушаал гарсан ч цалинг бодохдоо үндсэн цалингаас бууруулаагүй тухайн сарын ур чадварын нэмэгдлийг хасаж тооцон олгосон. Мөн сахилгын шийтгэлтэй албан хаагчдад үр дүнгийн урамшуулалт цалинг олгосон.
12. Ахлах сувилагч О.Шүрэнцэцэгт амбулаторын сувилагчийн ажлыг хавсруулж 20%-иар 939.3 мянган төгрөг, лаборант Б.Хандсүрэнд вакциначторыг хавсруулж 20%-иар 1245.3 мянган төгрөг, сургалтын арга зүйч С.Сийлэгмаад няравын ажлыг хавсруулж 20%-иар 629.4 мянган төгрөг, нярав Г.Энхтуяад сувилагчийн ажлыг хавсруулж 20%-иар 721.0 мянган төгрөг, сувилагч Д.Шинэбаярт ариутгагчийн ажлыг хавсруулж 15%-иар 703.0 мянган төгрөгийг тус тус өгч батлагдаагүй орон тооны ажлыг хавсруулан 4238.0 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон.
13. Төсөл хөтөлбөрийн зардлаас 3008.2 мянган төгрөг, шатахууны зардлаас 411.7 мянган төгрөг, урамшуулалт цалингийн зардлаас 462.3 мянган төгрөг, түлш халаалтын зардлаас 1039.5 мянган төгрөгийн, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас 1850.0 мянган төгрөг, урсгал засвар бусад материалын зардлаас 2062.5 мянган төгрөг нийт 8834.3 мянган төгрөгийг нярав С.Сийлэгмаагийн Төрийн банкин дахь 106600101960 тоот харилцах дансаар дамжуулан гаргасан ч бэлэн мөнгөний тайлан гаргаагүй, хувь хүний орлогын албан татвар тооцоогүй байна.
14. ЭМТ-ийн эрхлэгч Д.Жаргалсайханыг их эмчийн цалингаар цалинжуулж, эрхлэгчийг хавсран ажилласны 40 %-ийг олгох байтал эрхлэгчийн цалингаар цалинжуулж их эмчийн 40%-иар хавсруулан ажиллуулснаар шийдвэр гарч цалинжуулсан байна.
15. Эрүүл мэндийн төвийн эрхлэгч Ц.Гиймаад 2015 оны 1 улиралд ажлын шалгуур үзүүлэлтийг дүгнэсэн баримт болон эрх захирагчийн шийдвэргүйгээр 235.1 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалин олгосон.

16. Эрүүл мэндийн төвийн эрхлэгч эмч Д.Жаргалсайханд Рашаант сумын Засаг даргын 2016 оны 1 улирлын ажлыг дүгнэж үндсэн цалингийн 30%-иар урамшуулж 180.8 мянган төгрөгийн, 2 улирлын ажлыг дүгнэж үндсэн цалингийн 42%-иар урамшуулж 253.2 мянган төгрөгийн урамшууллыг шалгуур үзүүлэлтийг дүгнэж, шийдвэргүйгээр үр дүнгийн болон урамшуулалт цалин олгосон байна.
17. Эмийн тайлангийн үлдэгдэл 840.5 мянган төгрөг байхад, санхүүгийн тайлангийн үлдэгдэл 10707.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэйгээр тайлагнаж 9866.7 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16.5.7 дахь заалтыг зөрчин санхүүгийн тайланг буруу тайлагнасан байна.
18. Эмийн тайлангийн дансны үлдэгдэл 944.3 мянган төгрөг байтал 840.5 мянган төгрөгөөр гаргаж 103.8 мянган төгрөгийн эм дутагдсаныг шалгалтын хугацаанд барагдуулав.

Авсан арга хэмжээ, мэргэжлийн туслалцаа, зөвлөгөө өгсөн байдал

Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж таслан зогсоох зорилгоор 2 заалттай 1 албан шаардлага, 1 заалттай 496.3 мянган төгрөгийн төлбөрийг аймгийн төсөвт төвлөрүүлэхээр акт тогтоолоо. Шалгалтын хугацаанд 5 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

Дүгнэлт

Тус ЭМТ-д Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.1, 7.7 дахь заалтууд, агуулахын бүртгэлийн дэвтэр хөтлөөгүй, шатахууныг хэтрэлт, хэмнэлтээр тооцож акт үйлдээгүй, төсвийн тухай хуулийн 16.5.5, 16.5.7 дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй, эмийн нярав, нягтлан бодогчийн тайлан зөрүүтэй байгаа нь нягтлан бодогч няравын тайлангаар тайлан мэдээ гаргадаггүй зэрэг нь байгууллага дотооддоо бүртгэлээр тавих дотоодын хяналт хийгдээгүй гэж дүгнэлээ.

Цаашид анхаарах асуудал

Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, төсвийн тухай хуулийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах

Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоодын хяналт шалгалтыг тогтмол хийж санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх

Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу албан ёсны баримтыг үндэслэн зарцуулж байх

Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоож, давтан гаргахгүй байх талаар анхааран тодорхой ажил зохион байгуулж, акт, албан шаардлагын биелэлтийг албан тоотоор хүргүүлж ажиллах

БИЧСЭН: САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
БАЙЦААГЧ О.ГАНТУЯА